



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ



БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ

ДААТГАЛ • ЭРСДЭЛ • НӨХӨН ТӨЛБӨР




БИДНИЙ ТУХАЙ

Бодь Даатгал ХК 1995 онд Монголын анхны арилжааны даатгалын компаний нэг болон байгуулагдаж өдгөө 29 дах жилдээ 21 аймаг 330 сум 26 салбарт 200 гаруй ажилтан, албан хаагч, 1000 гаруй төлөөлөгчид 250 мянган харилцагчдадаа даатгалын үйлчилгээг хүргэн, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

2020 оны 6 дугаар сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааныхаа 15 хувийг санал болгон, эзэмшүүлсэнээр нээлттэй хувьцаат компани болсон.

Бид салбартаа тэргүүлэгч байр сууриа хадгалсаар өнөөдрийн байдлаар нийт хөрөнгө 32.6 тэрбум төгрөг, харилцагчийн тоо 250 000-д хүрч, нөхөн төлбөр олголтоороо сүүлийн 3 жил салбартаа тэргүүлсээр байна.

Дэлхийд тэргүүлэгч давхар даатгалын AXA групптэй 2015 оноос хойш хамтын ажиллагааг эхлүүлсэнээр Монгол хүний онцлогт тохирсон "BODI+Global Healthcare" олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ нэвтрүүлж, эрүүл мэндийн салбарт даатгалын ашиг тусыг нэмэгдүүлэн, цаашлаад өвчнийг эрт илрүүлэх, бүрэн эмчлүүлэх тал дээр санхүүгийн бодит дэмжлэг болон ажиллаж байна. Мөн даатгуулагчдадаа андеррайтингийн шинэ боломжийг нээн өгсөнөөр харилцагчдынхаа эрсдэлийг бүрэн хамгаалж, санхүүгийн баталгаатай байдлыг ханган, эрсдэлээ факультатив, трити, фронтинг хэлбэрээр олон улсын тэргүүлэх давхар даатгалд байршуулан ажиллаж байна.





БИД ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Манай баг БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛААР МЭРГЭШСЭН таны бизнесийн бүхий л үе шатанд тулгарч болзошгүй асуудал бэрхшээл, эрсдэлийг хамгийн зөв удирдаж, зөвлөх чинь байж чадах туршлагатай мэргэжилтнүүдийг нэгтгэсэнээр таны хамгийн сайн хамтрагч, зөвлөгч байж чадна.

Та ямар ч төрлийн бизнес эрхэлдэг байж болох ба Монгол орны бүхий л нутаг дэвсгэрт, эсвэл Дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг, мөн худалдааны өргөн сүлжээ бүхий үйл явцыг удирддаг бол бид танд хамгийн хэрэгтэй хамтрагч байхдаа баяртай байх болно.

Дэлхий дахинд байгууллагын даатгалын үйлчилгээний онцлого нь нэг ижил загвар, бүтээгдэхүүнээр даатгалын хамгаалалт авахад тохиромжгүй, өөр хоорондоо онцлог бизнесүүд байдаг тул бид зөвхөн танай байгууллагын онцлогт нийцсэн даатгалын тусгай хамгаалалтыг санал болгож, таны сонирхолд бүтээгдэхүүнээ нийцүүлэн, эрсдэлийг найдвартай байршуулан ажилладаг мэргэжлийн багаас тусалцаа авахдаа санаа амар байж болно.

Бид таны бизнест хүндрэл учруулж болзошгүй хохирлыг хариуцахаас гадна эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүх талын зөвлөх үйлчилгээг үзүүлж байна. Үүнд: Эрсдэлийн үнэлгээг мэргэшсэн баг хийж гүйцэтгэн, Монгол улсын зөвлөх инженерээр удирдуулсан багаар эрсдэлийн шинжилгээ хийж олон улсын стандартад нийцсэн зөвлөмж боловсруулж өгөх, даатгал болон эрсдэлийн удирдлагын цогц сургалт хийх зэргээр эрсдэлийн менежментийн тэргүүлэх шийдлүүдийг даатгуулагч, харилцагчдадаа санал болгох замаар таны ойрын зөвлөх болон ажиллах болно.





БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛ

Бизнесийн өөр хоорондоо ялгаатай байгууллагууд буюу Улсын, хувийн өмчийн, Олон Улсын, Гадаадын хөрөнгө оруулалттай болон Үндэстэн дамнасан корпорацуудад шаардагддаг олон төрлийн даатгалыг бид Дэлхийд хүлээн зөвшөөрөгддөг даатгалын бодлого, гэрээний стандарт нөхцлийн дагуу таны хүсэл сонирхолд нийцүүлэн дараах бүтээгдэхүүнүүдээр дамжуулан санал болгодог.





Байгууллагын хөрөнгийн даатгал

Барилга, байгууламж, үйлдвэр, дэд станцууд, тэдгээрийн дотор агуулагдах тоног, төхөөрөмж болон бусад хөрөнгүүд нь таны бизнесийг тасралтгүй явуулах үнэлж баршгүй үнэт зүйл ба эдгээр нь олон янзын эрсдэлд өртөмтгий байх нь элбэг. Та хөрөнгөө даатгуулсанаар эдгээр алдагдлаас зайлсхийхээс гадна бизнес саатсан үед олох байсан ашиг орлогоо бизнес тасалдлын даатгалаар нөхөн олох боломжтой.



Автотээврийн хэрэгсэлтэй холбоотой даатгалууд

Таны өмчлөлийн болон эзэмшлийн эсвэл түрээсээр ашигладаг бүх төрлийн автомашин, тусгай зориулалтын машин механизм болон Хүнд даацын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн чиргүүл болон бусад техникүүдийг даатгана. Монгол улсын нутаг дэвсгэрт болон БНХАУ, ОХУ-ын хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үеийн бүх төрлийн эрсдэлийг багтаана.



Барилга угсралт, төслийн даатгал

Таны захиалсан эсвэл гүйцэтгэж буй барилга, дэд бүтэц, зам гүүр зэрэг бүхий л ажлыг төсөл эхлэх хугацаанаас дуусах хүртэл төслийн талбайд гарах бүх эрсдэлийг цогцоор нь даатгадаг бүтээгдэхүүн. Энэ нь төслийн талбай дахь эд хөрөнгө, бараа материал, техник тоног төхөөрөмжөөр зогсохгүй тухайн талбайд гарсан ослоос үүдэн гуравдагч этгээдэд учирсан хохирол болон төсөлд оролцогч бүх талуудын ажилтны амь насны даатгалтай хамт бүрэн шийддэг дэлхий дахинд хамгийн түгээмэл даатгал.



Ачаа, тээврийн даатгал:

Бүхий л төрлийн бизнесийн орчинд тоног төхөөрөмж, бараа материалаа гаднаас татах, эсвэл экспортод гаргах хэрэгцээ тулгардаг. Тэгвэл та энэхүү үйл ажиллагааг эрсдэлгүй, тасралтгүй удирдахыг хүсвэл танд олон улсын ачаа тээврийн даатгал болон дотоодын ачаа тээврийн даатгал зайлшгүй шаардлагатай. Энэ эрсдэлээ бүрэн хаасанаар таны үндсэн бизнесийн үйл ажиллагаа тогтвортой, гэнэтийн бэрхшээлээс шалтгаалан саатах, доголдох эрсдэлээс бүрэн сэргийлэх боломжтой.



Байгууллагын хариуцлагын багц даатгал

Та нэг гэрээгээр а) Байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй гуравдагч этгээдэд учруулж болзошгүй хохирлын өмнө хүлээх хариуцлага, б) Зах зээлд нийлүүлж буй Бүтээгдэхүүн, үйлчилгээний улмаас хүлээх аливаа хариуцлага, Ажилтан албан хаагчдын амь нас эрүүл мэндийн өмнө хуулиар хүлээх хариуцлага зэргээ цогцоор нь даатгуулах боломжтой. Ингэсэнээр эдийн засгийн хэмнэлт, учирч болзошгүй эрсдэлүүдээ бүрэн удирдах, тэдгээртэй холбоотой гэнэтийн зардал, шүүхийн нэхэмжлэлүүдээс сэргийлэх боломжтой.



Цахим халдлагын даатгал: Cyber insurance

Цахим халдлагаас хамгаалах даатгал нь Даатгуулагчийн бизнест өндөр хэмжээний хор хохирол учруулах сүлжээний аюулгүй байдлын осол, кибер халдлага болон мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хадлагын үед хариу арга хэмжээ авахад тусалдаг ба кибер хадлагын улмаас таны бизнесийн нэр хүндэд учирч болзошгүй хохирлыг хязгаарлахад ихэвчлэн гардаг өндөр өртөгтэй зардлыг нөхөхөд тусалдаг.



Мэргэжлийн хариуцлагын даатгал

Энэ төрлийн даатгал нь таны үзүүлсэн мэргэжлийн үйлчилгээнд алдаа гарах, эсвэл таны эсрэг үйлчлүүлэгчээс гаргасан нэхэмжлэл, гомдол бүхий маргаанаас үүдэн гарах хариуцлагыг даатгасанаар хохирлыг таны өмнөөс шийдвэрлэх, хариуцлагын даатгалын төрөл юм. Аливаа зөвлөх үйлчилгээ, нарийн мэргэжил, тусгайлсан ур чадвар шаардлагатай ажил гүйцэтгэхэд танд энэ даатгал зайлшгүй хэрэгцээтэй.



Ажилтны даатгал

Бизнесээ амжилттай, тогтвортой явуулах гол хүчин зүйл нь хүний нөөцийн бодлого юм. Орчин үед хүний нөөцийг өндөр бүтээмжтэй, үр өгөөжтэй урт хугацаанд тогтоон барих гол хэрэгсэл нь Даатгал болон хөгжиж байна. Та ажилтнаа болон тэдгээрийн гэр бүлийг хувийн Эрүүл мэндийн болон Амь насны даатгалд хамруулсанаар ажилтан жил ирэх тусам өсөн нэмэгдэх өндөр хамгаалалт бүхий даатгалын боломжийг хүртсэнээр тогтвортой ажиллах суурь болох юм.



ДАВХАР ДААТГАЛ

Бид дэлхийн шилдэг брокер, давхар даатгагчидтай урт хугацааны, тогтвортой харилцааг хөгжүүлэн, давхар даатгалын борлуулалтаар зах зээлд тэргүүлэн ажиллаж байна.

Өөрсдийн хөрөнгөөс давсан томоохон хэмжээний эрсдэлийг давхар даатгалын брокеруудаар дамжуулан олон улсын зах зээл дээр амжилттай байршуулж, харилцагчийн бизнес, үйл ажиллагаа, эрсдэлийн түвшин зэрэг онцлогт нь тохирсон хамгаалалт, өрсөлдөхүйц үнэ, төлбөрийн нөхцөл, нөхөн төлбөрийн түргэн шуурхай шийдвэрлэлт зэрэг найдвартай хамгаалалтыг санал болгон ажиллаж байна.

Монголын стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдэд анхдагч даатгалын үйлчилгээ үзүүлж, мэргэжлийн андеррайтерийн тусламжтайгаар харилцагчдадаа даатгалтай холбогдолтой зөвлөх үйлчилгээ, эрсдэлийн үнэлгээ, сургалт, техник туслалцаа зэрэг харилцагчийн халамж, үйлчилгээг үзүүлж байна.

Бизнесийн тогтвортой байдлыг ханган ажиллах нь бизнесийн байгууллагын гол зорилт юм. Учирч болох аливаа эрсдэлээс хамгаалах хамгийн чухал хөшүүрэг бол ДААТГАЛ. Бид бизнесийн салбарын онцлогт тохирсон даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллахын зэрэгцээ эрсдэл өндөр уул уурхай, тээвэр, барилгын салбаруудад давхар даатгагчдын хамт тусгайлан боловсруулсан олон Улсын жишигт нийцсэн даатгалын хамгаалалтын үйлчилгээг үзүүлж байна. Бид таны бизнесийн итгэл даасан түнш, мэргэжлийн зөвлөх байх болно.





Уул
уурхай



Барилга,
дэд бүтэц



Тээвэр
ложистик



Үйлдвэр,
гадаад дотоод
худалдаа



Эрүүл мэнд,
эмнэлгийн
үйлчилгээ



Банк санхүүгийн
салбар



Аялал
жуулчлал



ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Бизнесийн тогтвортой байдлыг ханган ажиллах нь бизнесийн байгууллагын гол зорилт юм. Учирч болох аливаа эрсдэлээс хамгаалах хамгийн чухал хөшүүрэг бол ДААТГАЛ юм. Бид бизнесийн салбарын онцлогт тохирсон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллахын зэрэгцээ эрсдэл өндөр уул уурхай, тээвэр, барилгын салбаруудад давхар даатгагчдын хамт тусгайлан боловсруулсан олон Улсын жишигт нийцсэн даатгалын хамгаалалтын үйлчилгээг үзүүлж байна. Бид таны бизнесийн итгэл даасан даатгагч, мэргэжлийн зөвлөх байх болно.





Уул уурхай

УУЛ УУРХАЙ

Уул уурхай, ашигт малтмалын салбарт бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүх төрлийн байгууллагын багц даатгалын үйлчилгээг санал болгодог.


Дэлхийн нэр хүнд бүхий давхар даатгагчтай хамтран бид тус салбарын онцлогт тохирсон “уул уурхайн багц даатгал”-ын үйлчилгээг уян хатан нөхцөлтэйгөөр түргэн шуурхай хүргэж байгаа нь уул уурхайн салбарын эрсдэлийг бууруулж, найдвартай аюулгүй ажиллагааг хангахад бодит түлхэц болж байна.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Байгууллагын хариуцлагын даатгал
- Ажилтны амь нас, гэнэтийн ослын даатгал
- Ажил олгогчийн хариуцлагын даатгал
- Уурхайн барилга, байгууламж, кемп, үйлдвэр тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийн даатгал
- Хариуцлагын даатгал
- Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгал
- Тээврийн хэрэгсэл, операторын хариуцлагын даатгал

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- Эрсдэлийн үнэлгээ
- Мэргэшсэн андеррайтингийн баг
- Ноцтой эрсдэлийн сургалт
- Ажилтанд зориулсан халамжийн цогц хөтөлбөр
- Эрүүл мэндийн даатгалын нэмэлт боломжууд/ Урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг
- Төлбөрийн уян хатан нөхцөл



Барилга, дэд бүтэц

БАРИЛГА, ДЭД БҮТЭЦ

Барилга, зам гүүр, дэд бүтцийн салбар нь Олон улсын даатгалын зах зээлд эрсдэлийн түвшнээр дээгүүрт ордог бөгөөд байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө их байдгаас гадна гэнэтийн аюул осол гарах нь түгээмэл байдаг.

Иймд энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд ирээдүйд учирч болзошгүй томоохон гэнэтийн хохирлыг доорх төрлийн даатгалуудаар даатгуулан, эрсдэлээ удирдах боломжтойгоос гадна гуравдагч этгээд болон ажилтныхаа өмнө хүлээх хуулийн хариуцлагыг даатгалын гэрээгээр хамгаалах бүрэн боломжтой.


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.4.Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулна. Барилгын тухай хуулийн 8.1.Барилгын үйл ажиллагаанд оролцогч учирч болзошгүй эрсдэлийг даатгуулж болно гэж тус тус хуульчилсан байдаг нь даатгалын хэрэгцээ шаардлагыг зайлшгүй бий болгож буй юм.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Зам гүүрний барилга угсралтын иж бүрэн даатгал
- Бүх төрлийн мэргэжлийн хариуцлагын даатгал
- Байгууллагын эд хөрөнгийн даатгал
- Ажилтны гэнэтийн ослын даатгал
- Эрүүл мэндийн даатгал

НЭМЭЛТ ХАМГААЛАЛТ:

- Гал унтраах зардал
- Хог хаягдлыг зайлуулах зардал
- Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, шинжээчийн ажиллагаа, үнэлгээний зардал
- Галын эрсдэлийн үнэлгээг хийж зөвлөмж бэлтгэн өгөх
- Шаардлагатай тохиолдолд галын хор, аюулгүй ажиллагааны заавар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх аюулгүйн самбар зэргийг байршуулах
- Даатгалын сургалт ОУ-ын мэргэжлийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ/Risk survey хийлгэх



Тээвэр ЛОЖИСТИК

ТЭЭВЭР ЛОЖИСТИК

Бид таны бизнесийн онцлогт тохирсон даатгалын бүрэн хамгаалалтыг орчин үеийн тээвэр ложистикийн салбарын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн санал болгох ба Таныг бизнесээ эрсдэлгүй удирдах, тээвэрлэлтийн үеийн бүхий л үе шатанд эрдэлээс зайлсхийж үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцлийг бүрдүүлж чадна.

Энэ төрлийн даатгал нь харилцагчийнхаа өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсанаар найдвартай хамтын ажиллагааг бий болгох, үүгээр зогсохгүй орчин үед эрэлт хэрэгцээт бизнесийн боломжуудаа улам нэмэгдүүлэх, харилцагчийн тоо, борлуулалтаа өсгөх томоохон хөшүүргийн нэгэнд даатгал зүй ёсоор багтаж байна.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Ачаа тээврийн даатгал
- Тээвэр зуучийн хариуцлагын даатгал
- Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал
- Ажил олгогчийн хариуцлагын даатгал
- Ажиллагсдын хариуцлагын даатгал
- Ерөнхий хариуцлагын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал
- Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгал
- Гаалийн талбай болон агуулахад ашигладаг тусгай зориулалтын тоног, төхөөрөмжийн даатгал кран, өргөгчийн даатгал

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- Даатгалтай ачаа тээврийн үйлчилгээ
- Харилцагчийн итгэлцэл
- Мэргэшсэн андеррайтингийн баг
- Ажилтанд зориулсан халамжийн цогц хөтөлбөр
- Төлбөрийн уян хатан нөхцөл



Үйлдвэр, гадаад дотоод худалдаа

ҮЙЛДВЭР, ГАДААД ДОТООД ХУДАЛДАА

Үйлдвэрлэл, гадаад дотоод худалдааны салбар нь Монгол улсын эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдол бүхий чухал сектор ба бодлогын хэмжээнд “Экспортыг дэмжих төсөл”, баталгааны даатгал зэрэг тус салбарт бодит дэмжлэг болохуйц ажлуудыг шинээр санаачлан ажиллаж байна. Уг бодлогын хүрээнд үйлдвэрлэгч компаниудын бараа, бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд экспортолж, бизнесээ өргөжүүлэх боломжийг бий болгох зорилгоор “Экспортын зээлийн даатгал”-ыг даатгалын зах зээлд шинээр нэвтрүүлсэн.

Салбарын үйл ажиллагааг эрсдэлгүй, тасралтгүй явуулахын тулд барилга байгууламж, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах зэрэг багагүй хөрөнгө оруулалтыг шаарддаг. Тухайн эд хөрөнгөд гэнэтийн шинж чанартай аливаа эрсдэл учрахад үйлдвэрлэлийн процесс алдагдсанаар бизнес тасалдах, цаашлаад санхүүгийн томоохон алдагдал хүлээх эрсдэлийг бий болгодог тул энэхүү алдагдлаас хамгаалах даатгалын цогц бүтээгдэхүүнийг санал болгож байна.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Бизнес тасалдлын даатгал
- Үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, бараа материалын даатгал
- Ачаа тээврийн даатгал
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний хариуцлага
- Байгууллагын ерөнхий хариуцлага
- Ажил олгогчийн хариуцлага
- Ажилтны хариуцлага
- Эрүүл мэндийн даатгал
- Экспортын зээлийн даатгал

НЭМЭЛТ ХАМГААЛАЛТ

- Галын эрсдэлийн зөвлөмж
- Галын аюулгүй ажиллагааны зардал
- ХАБЭА сургалтын зардал
- Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, шинжээчийн ажиллагаа, үнэлгээний зардал
- Авран хамгаалах зардал
- Гал унтраах зардал, Хог хаягдлыг зайлуулах
- Хохирол үнэлгээний зардал
- Шүүхийн зардал

Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ

ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн салбарт тулгамддаг томоохон асуудал нь иргэдийн өвчлөл, эрүүл аюулгүй орчин, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмж юм. Бид урт хугацаанд Монгол хүнийг эрүүл амьдруулах, зөв дадалд хэвшүүлэх, өвчнийг аль болох эрт илрүүлэх эрмэлзэлтэйгээр эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэн ажиллаж байна. Хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, аливаа өвчийг хүндрүүлэхгүй бүрэн эмчлүүлэх түүнд шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар жаргалтай, элэг бүтэн иргэдийг бий болохыг зорьж байна.

“Бодь Даатгал” ХК-ийн хамт олон та бүхэнд ОУ-ын эрүүл мэндийн даатгалын салбарт 80 гаруй жилийн туршлагатай “AXA Life Health Re-Insurance Solutions” –ийн эрүүл мэндийн даатгалын компанид давхар даатгалтай “BODI+ Global Healthcare” олон улсын эрүүл мэндийн даатгалыг санал болгож байна. Олон улсын эрүүл мэндийн даатгал нь таны хэрэгцээ шаардлага дээр суурилсан BASIC, STANDARD, SMART, SPECIAL болон PREMIUM багцуудаас бүрдэх бөгөөд сонгосон багцаас хамаараад та нэг жилийн хугацаанд дотооддоо болон олон улсын 150 орчим оронд байрлах 12 мянга гаруй, чанарын өндөр стандарт бүхий нэр хүндтэй сүлжээ эмнэлэг, шинжилгээний төвүүдээр 100 мянгаас 2,5 сая хүртэлх ам.долларын эмчилгээ, үйлчилгээ авах боломжтой юм.

Мөн та манай Дотоодын Эрүүл Мэндийн “ЭРХЭМ” даатгалд хамт олон группээрээ даатгуулах боломжтой ба Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж буй бүхий л эмнэлгээр үйлчлүүлэн, эрүүл мэндтэй холбоотой зардлаа 50 сая төгрөг хүртэл шийдүүлэх бүрэн боломжтой.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Эмч, эмнэлгийн ажилтны хариуцлагын даатгал
- Эмнэлгийн хөрөнгийн даатгал
- Байгууллага болон хувь хүний “Эрхэм” эрүүл мэндийн даатгал
- Байгууллага болон хувь хүний “Bodi Global Healthcare” эрүүл мэндийн даатгал
- Гэнэтийн ослын даатгал

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- Эрүүл мэндийн халамжийн бодлого
- Мэргэшсэн даатгалын андеррайтингийн баг
- Туршлагатай нөхөн төлбөрийн зөвлөх эмч
- Шууд төлбөрийн үйлчилгээ



Банк санхүүгийн салбар

БАНК САНХҮҮГИЙН САЛБАР

Эдийн засгийн эрчимтэй өсөлтийг даган хурдацтай хөгжиж буй салбаруудын нэг нь банк, санхүүгийн салбар юм. Тус салбарт дэлхийн санхүүгийн хямралын нөлөө, хөрөнгө оруулалтын орчин, шийдвэр гаргагчдын байр суурь, хууль эрхзүйн орчин гээд олон хүчин зүйл нөлөөлдөг.

Мөн дижитал технологи болох хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан дижитал үйлчилгээг хөгжүүлж, харилцагч нартаа хүрч ажилладаг онцлог нь эрсдэлийн түвшнийг илүү их нэмэгдүүлж байдаг. Иймээс банк, санхүүгийн салбар нь даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаатайгаа уялдуулсанаар бизнес, хөрөнгө оруулалтын эрсдэлээ бууруулж, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлнэ.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Банкны бүрэн баталгааны даатгал
- Зээлийн эрсдэлийн болон төлбөр тасалдлын даатгал
- Удирдах ажилтны хариуцлагын даатгал
- Барилга байгууламж, тоног төхөөрөмж, барьцаа хөрөнгийн даатгал
- Мэргэжлийн хариуцлагын даатгал
- Олон нийтийн болон Байгууллагын хариуцлагын даатгал
- Ажилчдын гэнэтийн ослын даатгал
- Эрүүл мэндийн даатгал

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, шинжээчийн ажиллагаа, үнэлгээний зардал
- Хохирол үнэлгээний зардал
- Шүүх, өмгөөллийн зардал



Аялал жуулчлал

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх эгнээнд авч үзэн 2023-2025 оныг “Монголд зочлох жил”- болгон зарлаж, аялал жуулчлалын салбарыг дэмжин ажиллах болсонтой холбоотойгоор энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бизнесийн эрсдэлээ олон улсын жишгийн дагуу даатгуулах, үйлчлүүлэгч, аялагчдадаа эрсдэлгүй үйлчилгээ үзүүлэх шаардлага тулгамдаж байна.

Аялал жуулчлалын салбарын оролцогч талууд өөрийн бизнест учирч болзошгүй бүх төрлийн эрсдэлийг даатгалын гэрээгээр хамгаалах боломжтой бөгөөд ингэсэнээр энэ салбарт бизнес эрхлэгчид гэнэтийн аюул осол, төлөвлөөгүй өндөр зардлаас сэргийлэх эрсдэлийн менежментийг даатгалд шилжүүлэх жишиг олон улсад тогтсон. Өөрийн аялал жуулчлалын бизнесийн үндсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээ даатгуулахаас гадна үйлчлүүлэгчийн гэнэтийн эрсдэлийг доорх төрлийн даатгалд хамрагдсанаар шийдвэрлэх боломжтой.

ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- Жуулчдын амь насны даатгал
- Ажил олгогчийн хариуцлагын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Байгууллагын хариуцлагын даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал

НЭМЭЛТ ХАМГААЛАЛТ

- Байгууллага бүрд тохирсон багц даатгалын хөнгөлөлт
- Шүүхийн зардал /500,000 хүртэл/
- Тэмдэгтийн хураамж /250,000 хүртэл/
- Мэргэжлийн хариуцлагын даатгал



БИДНИЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТОМООХОН ТӨСЛҮҮД



Монголын газрын тос боловсруулах үйлдвэр бүтээн байгуулах төсөл



Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах” төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь 2017 оны 4 дүгээр сард эх орныхоо газрын тосны баялгийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хэрэгжиж эхлээд байна.

Усыг гүн цэвэрлэх үйлдвэр байгуулах төсөл



Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын сан, Компакт гэрээний санхүүжилтээр Монголд анх удаа усыг гүн цэвэршүүлэх болон хаягдал ус дахин боловсруулах хоёр томоохон үйлдвэр байгуулахаас гадна ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагуудын институцийн чадавхыг бэхжүүлэх, цогц хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна.

Сайншанд салхин парк төсөл



“Сайн шанд салхин парк” төсөл нь нийт 120 сая ам.долларын хөрөнгө оруулалттай 55 МВт-ын хүчин чадал бүхий салхин цахилгаан станцын бүтээн байгуулалт бөгөөд Дорноговь аймгийн Сайншанд сумын 100 мянган айл өрхийн цахилгааны хэрэглээг хангахуйц эрчим хүч үйлдвэрлэх юм.

“Тайшир-Алтай Ус Хангамж” төсөл



Бүгд найрамдах Австри улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй энэхүү төсөл нь Монголд анх удаа гадаргын усыг цэвэрлэн унд-ахуйн зориулалтаар ашиглах шинэ технологийг нэвтрүүлж, Алтай хотын 19 мянган хүн ам дэлхийн жишигт нийцсэн технологиор цэвэршүүлсэн, эрүүл ахуйн стандартад нийцсэн цэвэр усаар хангагдах ач холбогдолтой юм.



НӨХӨН ТӨЛБӨР

Нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг үнэн зөв шийдвэрлэх замаар харилцагчдын хохирлыг шуурхай барагдуулах нь даатгалын компанийн үйлчилгээний гол шалгуур билээ. Тиймээс бид сүүлийн 3 жилийн хугацаанд ослын тохиолдол үүссэнээс эхлээд нөхөн төлбөр олгох хүртэлх бүх дотоод процессыг цахимжуулсанаар ослын дуудлага, нөхөн төлбөрийн материалыг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх, нөхөн олговор олгох зэрэг процессыг хурдан, шуурхай шийддэг болох зорилго тавин ажиллаж байна.

Дэлхий дахинд технологийн салбар хурдацтай хөгжиж буй эринд технологийн үсрэнгүй хөгжил бидэнд өдрөөс өдөрт шинэ боломжуудыг нээсээр байна. Бид өөрсдийн туршлагад суурилан insurtech-ийн хамгийн сүүлийн үеийн чиг хандлагыг шингээсэн орчин үеийн программ хангамж, технологийг нэвтрүүлсэнээр цахим сувгаар баримтын бүрдүүлэлт хийн, нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэж байна.

Манай нөхөн төлбөрийн газар мэргэжлийн шинжээчдийн баг, хуульч, харилцагчийн үйлчилгээний алба бүрэлдэхүүнтэй ажиллаж, даатгуулагчид учирсан аливаа асуудлыг хуулийн хүрээнд ил тод түргэн шуурхай шийдвэрлэж байна.





ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Эрсдэлийн менежмент нь тухайн байгууллагад тохиолдох дотоод болон гадаад орчны тодорхойгүй байдлаас үүсэх эрсдэлийг удирдах юм. Компанийн хувьд эрсдэлийг үнэлэх, удирдах нь ахиц дэвшил, өсөлтөд саад болж болзошгүй нөхцөл байдалд бэлтгэх хамгийн сайн арга. Бид эрсдэлийн үнэлгээг Олон улсад зөвшөөрөгдсөн аргачлал, мөн өөрсдийн боловсруулсан үнэлгээний загвар дээр суурилан хийдэг ба харилцагч байгууллагынхаа өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болох аюул осол, тэдгээрээс үүсч болох эрсдэлийг хэмжиж, эрсдэлийн түвшнийг тодорхойлон зөвлөгөө өгч ажилладгаараа онцлог билээ.

Бид хэзээд танай байгууллагатай хамтарч ажиллахад бэлэн ба шаардлагатай сургалт, эрсдэлийн зөвлөх үйлчилгээ болон эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг хамтдаа удирдан ажиллахдаа таатай байх болно. Манай мэргэжилтнүүд танай байгууллагад эрсдэлийн талаарх зөвлөмж, зөвлөгөөг өгөхөөс гадна танай компанид учирч болзошгүй аюулыг тодорхойлон үнэлж, эрсдэлийг бууруулахад чиглэн ажиллаж байна.





+976 75054800
info@bodi-insurance.com

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойрог-3, Бодь цамхаг



bodi-insurance.com